



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/14

Номгон

Аймгийн хөгжлийн зөвлөгөөн зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17 дахь заалт, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн "Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай" 2/8 тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хонгор нутгийн хөгжлийн хэтийн бодлогыг төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотой тодорхойлох, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн "Хөгжлийн зөвлөгөөн"-ийг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсугай.

2.Тус зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Энхбаяр – Аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч

Нарийн бичгийн дарга: Т.Хишигбаатар - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: С.Байгалмаа – Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Д.Энхжаргал- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Д.Сарангарав- Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Г.Төртогтох – Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга

Г.Нэмэхбаяр- Цэргийн штабын дарга

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тамгын газрын дарга /М.Өнөржаргал/-т, зөвлөгөөнийг зохион байгуулах удирдамжийг боловсруулан, мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримталж зохион байгуулахыг ажлын хэсэг /Г.Энхбаяр/-т тус тус даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210033